

СУРГАЛТ-ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН НИЙГЭМШИЛТЭД УРЛАГААР ДАМЖУУЛАН НӨЛӨӨЛӨХ НЬ

*Б. Энхсайхан
Магистр оюутан*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

benhee951@gmail.com

Хураангуй: Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ялаар шийтгэгдэж нийгмээс тусгаарлагдан хүмүүжиж байгаа нийгэм, сэтгэл зүйн хувьд өвөрмөц онцлогтой өсвөр насны хүүхдүүдэд Урлагаар дамжуулан нөлөөлөх зорилгоор урлагийн заслын хөтөлбөрийг хэрэгжүүлж хөтөлбөрийн үр дүнг хүүхдүүдээс “Хөдөлгөөнт байшин мод хүн” сэтгэлзүйн хэрэгцээ тодорхойлох проектив тест болон Спенсийн “Стресс, түгшүүр”-ийн тест авч урлагийн хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: хорих ялаар шийтгэгдэж, нийгмээс тусгаарлагдсан өсвөр насныхан, нас, сэтгэл зүй, нийгмийн эмзэг байдал, урлагийг заслын хөтөлбөр

УДИРТГАЛ

Нийгэм байнга хувьсан өөрчлөгдөж байгаа өнөө цаг үед хамгийн түрүүнд эмзэг байдалтайгаар өртдөг хүн амын нэг хэсэг бол хүүхэд юм.

Хүүхэд гэдэг бол орчлон ертөнцийг цагаахан хүсэл мөрөөдлөөр амьдралаа төсөөлөн явдаг гэнэхэн амьтад өнөөдөр гэмт хэрэгтэн болж төмөр торны цаана сууж байна. Хүүхэд зайлшгүй хамгаалагдах, хэн нэгний харьяалалд орох шаардлагатай байдаг. Учир нь хүүхэд бие даан шийдвэр гаргах чадваргүй, хэн нэгний тусламж, халамж хэрэгцээтэй байдаг.

Манай улсын хүн амын тодорхой хувийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзэлдэг бөгөөд тэдгээр нь эцэг эх, асран хамгаалагчийн хяналтан дор нийгмийн харилцаанд орж байдаг.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар нийт 48656 хүн шүүхээр ял шийтгүүлснээс өсвөр насны хүн 1869 буюу 3.84%-ийг эзэлж байна. Түүнчлэн нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд явагдаж буй өөрчлөлт, шинэчлэлийн явцад ажилгүйдэл, ядуурал, түүнээс улбаатай архидалт, мансуурал зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд, эцэг, эх, асран хамгаалагчдаас үр хүүхдэдээ тавих хараа хяналт дутсанаас хүүхэд сургууль завсардах, гэр орноосоо дайжих, элдэв сөрөг нөлөөнд автах, улмаар гэмт хэрэг үйлдэх, гэмт халдлагад өртөх явдал сүүлийн жилүүдэд төдийлөн буурахгүй байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад сүүлийн таван жилд **287** хүүхэд хорих ял эдэлсэн байна.

Хүмүүжсэн хүүхдийн гэр бүл, нийгмийн байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах үр дүн гарч байна.

Нийт хорих ял эдэлсэн 287 хүүхдээс эрэгтэй-281 буюу 97,9%, эмэгтэй-6 буюу 2,1% Үүнээс:

- Бүтэн өнчин -39 буюу 13,5%
- Хагас өнчин буюу хойд эцэг эхийн асрамжинд-165 буюу 57,4%
- Эцэг, эх нь архины хамааралтай гэр бүлд өссөн – 48 буюу 16,7%
- Амьжиргааны дунд, түүнээс дээш болон гэр бүлийн хэвийн орчинд өсөж хүмүүжсэн 35 буюу 12,4% байна.

Дээрх судалгаанаас харахад ихэнх нь бүтэн болон хагас өнчин, эцэг эх нь салж хойд эцэг эхийн асрамжинд хүчирхийлэлд өртсөн, зүй бус харьцаа, хайхрамжгүй байдлаас болж хүүхдүүд гэмт хэрэгт холбогдож байна.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын хүүхдүүдийн нас, нийгэм, сэтгэл зүйн онцлог:

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын хүүхдүүдийн өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог:

Өсвөр насанд бие махбод, сэтгэл зүйн хувьд том хүн болох шилжилтийн үе юм. Өсвөр нас гэдэг нь хүүхэд насанд хүрэгчдийн эгнээнд шилжих хөгжлийн үе бөгөөд тэдний бие бялдар танин мэдэхүйн, нийгэмшихэд зөрчил ,өөрчлөлт бий болдог үе юм. Өсвөр нас бол хүний өсөлт бойжилт, сэтгэл санааны хамгийн чухал үе. Энэ үед хүүхдийн бие физиологи, сэтгэлзүй, харилцаа ,хандлага гэх мэт зүйлсэд гэнэтийн өөрчлөлтүүд гарч, олон асуудлуудтай нүүр тулгардаг шилжилтийн нас юм. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа хүүхдүүдийн дийлэнх хувь бага насандаа хайр халамж, хараа хялалтаар дутаж, сэтгэл зүйн гэмтэл авсан байдаг. Ромен Стриженец “Хямралын үед үзүүлэх үйлчилгээ” номондоо хямрал гэдэг нь аюултай нөхцөл байдал үүссэний улмаас дотоод тэнцвэрт байдал түүнийг даван туулахад үндсэн өөрчлөлт шаардлагатай байгаа нөхцөлийг хэлнэ хэмээн тодорхойлж хоригдох нь сэтгэл гутрал, хямралд өртөх магадлал 63 байдаг талаар дурдсан байдаг.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа хүүхдүүд хийсэн хэрэгтээ гэмшиж хоригдож байгаадаа гутрах, гэр бүл ойр дотны хүмүүсээ санах, суллагдан гараад нийгэм болон ойр дотны хүмүүс

нь хэрхэн хүлээж авахад санаа зовинож түгшүүрлэх гэх мэт сэтгэл зүйн асуудлуудтай байдаг.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын хүүхдүүдийн гэр бүл, нийгмийн байдал:

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад сүүлийн 5-н жилийн хугацаанп хүмүүжсэн нийт 287 хүүхдийн гэр бүл, нийгмийн байдлын судалгааны үр дүнгээс харахад нийт хүүдүүдийн 35 хүүхэд буюу 12,4% нь л амьжиргааны дунд, түүнээс дээш болон гэр бүлийн хэвийн орчинд өсөж хүмүүжсэн. Бусад 282 хүүхэд буюу 87,6% нь бүтэн өнчин, хагас өнчин буюу хойд эцэг эхийн халамжинд байдаг, эцэг эх нь архины хамааралтай гэх мэт гэр бүлийн ямар нэгэн асуудалтай, тогтворгүй гэр бүлд өссөн байна.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын хүүхдүүдийн боловсролын байдал:

Хүмүүжигч хүүхдүүд гэмт хэрэгт холбогдож шалгагдаж байх хугацаанд сэтгэл зүйн тогтворгүй байдал үүсч хичээлдээ анхаарах боломжгүй болох, гэр бүлийн тогтворгүй байдал, ядуурал гэх мэт шалтгааны улмаас хүмүүжиж байгаа хүүхдүүдийн дийлэнх хувь богино болон урт хугацааны хичээл сургууль завсардаж, хичээл сургуулийн хоцрогдолтой байдаг.

Нийгмийн харилцаа, танин мэдэхүйн байдал:

Нийгмийн харилцаа хязгаарлагдмал тэдний нийгмийн харилцаа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын албан хаагчид, багш нар, хамт хүмүүжиж байгаа хүүхдүүдээр хязгаарлагдана.Эрх чөлөөгөө хязгаарлуулан нийгмээс тусгаарлагдсан орчинд байгаа тул танин мэдэхүйн цар хүрээ хязгаарлагдмал байдаг.

Урлагийн заслын талаарх ойлголт:

Урлагийн сэтгэл засал нь хүнд үгээр хэлж, тайлбарлахад хүндрэлтэй, бэрхшээлтэй асуудлыг урлагийн хэрэгслүүдийн тусламжтайгаар илэрхийлж асуудлынхаа мөн чанарыг ойлгох, гарах гарцаа тодорхойлох, даван туулах чадвараа нэмэгдүүлэх, өөр асуудалд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд тусалдаг.

Сэтгэл зүйн асуудлаа даван туулахад "урлаг" -ийн нөлөө, түүний үр дүн өндөр болохыг орчин үеийн шинжлэх ухаанд батлаад байгаа юм. Эмчилгээний арга барил нь ч эрчимтэй хөгжиж байна. Зөвхөн сэтгэлзүйн

төдийгүй "хавдар" зэрэг хүнд өвчний үед уг эмчилгээ ач тустай аж. Урлаг гэдэгт дуу, бүжиг, зураг гэх мэт бүхий л төрлүүд багтдаг байна. Манай улсын хувьд урлагийн сэтгэл заслын олон төрлөөс "дүрслэх урлаг" -аар дамжин засах эмчилгээ түлхүү нэвтэрсэн.

Урлагийн сэтгэл засал нь дэлхийн бусад улс орнуудад дэлгэрээд удаж байна. Манай улсад нэвтрээд удаагүй.

Дэлхийн II-р дайны үед урлагийн сэтгэл засал анхлан үүссэн гэж үздэг. Дэлхийн хоёрдугаар дайны дараа Европт сэтгэцийн асуудалтай хүмүүсийн тоо нэмэгдсэн. Дайнд гэр бүлийн хүмүүсээ алдсанаас болж өнчрөх, хагацах, гашуудах зовлон үзсэн хүмүүс зөвхөн эмэн эмчилгээнээс гадна эмийн бус аргаар эдгэж, өөрчлөгдөх боломжтой гэж сэтгэл зүйчид үзсэн.Тухайн үед хүмүүс "урлаг" -ийн төрлүүд болох дуу, бүжиг, зураг зэргийн тусламжтайгаар сэтгэлээ сэргээн, тайвширдаг байсан ба энэ нь сэтгэл заслын эмчилгээний чухал төрөл болсон байна. Урлагийн сэтгэл засал буюу "Арт терапи"-ийг үндэслэгч нь Адриан Хилл зураач. Тэрээр сүрьеэ өвчин тусаж эмнэлэгт удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлж байхдаа "зураг" зурдаг байж. Зурах мэдрэмж нь эрүүл мэндэд нь эерэгээр нөлөөлж, өвчний эдгэрэлт нь хурдан явагдаж байгаа мэт санагдсан байна.

Эмнэлгээс гарсныхаа дараа "урлаг" сэтгэл санааг засах, тайван байлгахад чухал ач холбогдолтой гэдгийг дэлгэрүүлж эхэлсэн бөгөөд, эмчилгээний нэг төрөл болтол нь хөгжүүлсэн байдаг. Манай улсын хувьд энэ эмчилгээний төрлийг 1980 оноос СЭМҮТ-д ашиглаж эхэлсэн. Сэтгэл зүйн засал эмчилгээний олон аргуудаас урлагийн заслын онцлог нь:

Хүний мэдрэхүйн дурсамж гэж бий. Ямар нэг үнэр үнэртэхэд тухайн үнэртэй холбоотой дурсамж санагддаг. Эсвэл хөгжим, чимээ сонсоход тухайн хөгжимтэй холбоотой дурсамжууд сэдэрдэг. Үүнийг "мэдрэхүйн дурсамж" гэж томъёолдог. Төхиолдож байгаа аливаа үйл явдал санах ойноос гадна мэдрэмжинд үлддэг. Мэдрэмжинд хадгалагдсан асуудлуудаа үгээр илэрхийлж ярихад нэлээн төвөгтэй. Ийм үед тухайн мэдрэмж, асуудлыг нь гаргаж ирэхийн тулд урлагийн сэтгэл заслын аргуудыг ашигладаг. Үүгээрээ бусад сэтгэл заслын эмчилгээнээс ялгаатай.

Урлагийн сэтгэл заслын хамгийн чухал зүйл нь бүтээлээ задлан ярилцах байдаг. Жишээ нь зураг зурахад бусад хүмүүст зүгээр л энгийн гоё зураг шиг харагдаж болно. Харин арт терапевст буюу урлагийн сэтгэл засалч тэр зурганд ямар зураасууд, өнгө байна, юу илэрхийлэхийг хүсэж байгааг нь ажиглан, таньж уншдаг. Тэгээд онцгой санагдсан зүйлүүд дээр нь тулгуурлаж ярилцдаг. Тухайн өвчтөн зургаа тайлбарлаж ярих явцдаа асуудлаа олж хараад эмчийн тусламжтайгаар гарах замаа мэдэж авдаг.

ТУРШИЛТ СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Урлагийн заслын хөтөлбөрийн үр дүнг Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын 17 хүүхдээс дараах тестүүдийг авсан. “Хөдөлгөөнт байшин мод хүн” сэтгэлзүйн хэрэгцээ тодорхойлох проектив тестэд тулгуурлан урлагийн заслын хөтөлбөрийн өмнө, дараа хүүхдүүдээс тоон боловсруулалт хийж урлагийн заслын хөтөлбөрийн үр нөлөөг үнэхлэхийг зорьсон.

Урлагийн заслын хөтөлбөр 7 удаагийн бүлгийн уулзалт, сургалт явагдсан бөгөөд хөтөлбөрийн зорилго нь сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж буй 15-18 насны хүүхдүүдэд урлагийн сэтгэл заслаар дамжуулан сөрөг мэдрэмжийг гадагшлуулах, өөрийгөө илэрхийлэх, өөрийгөө ойлгох, өөрийгөө хүлээн зөвшөөрөх, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэж байв.

Сургалтын хугацаанд 17 оролцогч, 7 удаагийн бүлгийн сургалтанд хамрагдав. Сургалтанд хамрагдсан 17 хүүхдээс 11 хүүхэд нь бүрэн тогтмол хамрагдаж, 6 хүүхэд нь 2-4 удаагийн ирцтэйгээр хамрагдсан байна. Сургалтанд бүрэн ирцтэй хамрагдсан 11 хүүхдүүдийн 7 буюу 64% нь стресс түгшүүрийн түвшин буурч, 4 хүүхэд буюу 23,5% д нь түгшүүрийн мэдрэмж нэмэгдсэн байна. Энэхүү түгшүүрт мэдрэмж нэмэгдэх үзэгдэл нь сэтгэл засал үйлчилгээнд оролцогчдод бодит байдлыг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой илэрдэг хариу урвалуудын нэг байдаг тул үүнийг бид үр дүнгийн нэг хэлбэрээр хүлээн авах боломжтой.

Хөтөлбөрийн хэрэгжилтээс дүгнэхэд урлагийн сэтгэл заслын бүлгийн уулзалтыг ганцаарчилсан уулзалт зөвлөгөөтэй нэгтгэн СХТБ-ийн хүүхдүүдэд явуулах нь тэдний сэтгэлзүйн түгшилт, стресс, сөрөг мэдрэмжийг бууруулж, өөрийгөө олох, өөрийгөө мэдэрч, бусдыг хайрлаж, ирээдүйгээ үнэн бодитоор үр дүнтэй төлөвлөх, дасан зохицож чадварыг нэмэгдүүлэхэд туслах зэрэг ач холбогдолтой нь харагдаж байна. Мөн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд энэхүү сургалтыг үргэлжлүүлэх хусэлтэй байгаагаа илэрхийлж байсан нь хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага өндөр байгааг харуулж байна.

Хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн сургалтын өмнө ба дараах зургаас харуулбал:



Зураг:1

/Хүн мод байшин, Өмнөх зураг Э.Б /



Зураг 2:
/Хүн мод байшин, Дараах зураг Э.Б /

<p>Хүүхдийн сэтгэл зүйн байдал: Зургаас дүгнэхэд далд байгаа гадагшлуулах хэрэгцээтэй уур бухимдал, түрэмгийлэл гэр бүлтэй холбоотой болон эсрэг хүйст чиглэсэн стресс, түгшүүрийн мэдрэмж өндөр, сэтгэл гутрах хандлагатай.</p> <ul style="list-style-type: none"> Хүүхдийн эн тэргүүний хэрэгцээ нь өөртэй холбоотой, өөрт чиглэсэн байж болзошгүй уур бухимдал түрэмгийллийг гадагшлуулах
<p>Гарсан ахиц өөрчлөлт: Сургалтын дараах зурагт гарсан өөрчлөлтөөс дүгнэхэд гэр бүл болон эсрэг хүйст чиглэсэн түгшүүрийн мэдрэмж буурсан боловч өөрт чиглэсэн түрэмгийллийн хандлага хэвээр байна.</p>

Судлуулагч: Ш

Судалгаа № 1. Үйлчлүүлэгчийн түгшүүрт байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг илрүүлэх зорилготой. 6 түвшинд илрүүлнэ.

Асуулга 1		Асуулга 2	
Тусгаарлагдах айдас	8	Тусгаарлагдах айдас	6
Нийгмийн айдас	10	Нийгмийн айдас	8
Улигт бодол	9	Улигт бодол	7
Паник	10	Паник	9
Биений осол	8	Биений осол	9
Ерөнхий түгшүүр	11	Ерөнхий түгшүүр	9
Нийт оноо	56	Нийт оноо	48

Дээрх судалгаанаас эхний асуулгаар 56 буюу сэтгэл зүйн түгшүүрт байдал өндөр байгаа байгаа сургалтын дараах үнэлгээгээр 48 буюу 8 үзүүлэлтээр буурсан нь бидний хувьд ахиц юм. Цаашид түгшүүрин байдал дээр анхаарч дахин бууруулах, сэтгэл зүйн хувьд ганцаарчилсан зөвлөгөөнд хамруулах шаардлагатай гэж харж байна.

Судалгаа № 2. Сэтгэл зүйн хэрэгцээ тодорхойлох проектив тест. Тестээр хувь хүний хөгжих хэрэгцээ, аюулгүй байдлын хэрэгцээ, бие махбодын хэрэгцээг тодорхойлно.

<p>Хүүхдийн нэр: Ш</p> <p>Сурагчийн сэтгэл зүйн байдал: Зурсан зургаас дүгнэхэд сэтгэл зүйн хувьд хамгаалалт, өөрийгөө буруутгах мэдрэмж, уур бухимдлын түвшин өндөртэй. Өөрийгөө үнэлэх үнэлэмж сул, өөртэй холбоотой эсрэгцсэн мэдрэмжтэй. Хувь хүний хөгжил, ирээдүйд чиглэсэн түгшүүр байж болзошгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> Хүүхдийн эн тэргүүний хэрэгцээ нь өөртэй холбоотой эсрэгцсэн мэдрэмжийг цэгцлэх, өөрийгөө болон бодит байдлыг хүлээн зөвшөөрөх,
<p>Гарсан ахиц өөрчлөлт: Өөртэй холбоотой эсрэгцсэн мэдрэмж буурч болон түгшүүрийн мэдрэмж буурсан байна.</p>
<p>Цаашид авах арга хэмжээ: Цаашид сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг тасралтгүй өгөх хэрэгтэй.</p>

Дүгнэлт: Нийт 2 тестийн үнэлгээгээр судлуулагчийн өөртэй холбоотой эсрэгцсэн мэдрэмж болон түгшүүрт мэдрэмж буурсан байна. Цаашид

түгшүүрт байдалд дахин бууруулах талд анхаарч, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд хамруулах хэрэгтэй.

1. Судлуулагч: С

Судалгаа №1 Үйлчлүүлэгчийн түгшүүрт байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг илрүүлэх зорилготой. 6 түвшинд илрүүлнэ.

1-р асуулга		2-р асуулга	
Тусгаарлагдах айдас	4	Тусгаарлагдах айдас	1
Нийгмийн айдас	2	Нийгмийн айдас	3
Улигт бодол	8	Улигт бодол	6
Паник	1	Паник	1
Биеийн осол	2	Биеийн осол	0
Ерөнхий түгшүүр	6	Ерөнхий түгшүүр	7
Нийт оноо	23	Нийт оноо	18

Дээрх хүснэгтээс 1,2-р асуулгаас түгшүүрт байдлыг харвал судлуулагчийн түгшүүрт байдал хэвийн хэмжээнд байна. Судлуулагчийн түгшүүрт байдлын хэмжүүр нь харьцангуй тогтвортой байгаа ч хооронд нь үзүүлэлтүүдийг харьцуулан харвал буурсан байгаа нь харагдаж байна. Ерөнхий түгшүүрийн хэмжүүр 1-р нэмэгдсэн нь нөхцөл байдлаас үүдэлтэйгээр бий болдог үзүүлэлт учир хэвийн түвшинд гэж харж байна.

Судалгаа №2 Сэтгэл зүйн хэрэгцээ тодорхойлох проектив тест. Тестээр хувь хүний хөгжих хэрэгцээ, аюулгүй байдлын хэрэгцээ, бие махбодын хэрэгцээг тодорхойлно.

Хүүхдийн нэр : С
Сурагчийн сэтгэл зүйн байдал: Зурсан зургаас дүгнэхэд сэтгэл зүйн хамгаалалт өндөр, гэр бүлтэй холбоотой хоосон мэдрэмжтэй, гэр бүлээс зугатах, зай барих хандлагатай, гэмших, өөрийгөө буруутгах мэдрэмж өндөр, хувь хүний хөгжилтэй холбоотой мэдрэмж сул буюу өөрийн хөгжилд сэтгэл хангалуун бус байх хандлага байна. Мөн бие махбодтой холбоотой сөрөг мэдрэмжтэй, өөрийгөө хүлээн зөвшөөрөхгүй байх, сэтгэл зүйн байдлаа бусадтай хуваалцах нээлттэй харилцахаас татгалзаж өөрийгөө хааж байх магадлалтай. <ul style="list-style-type: none"> Хүүхдийн эн тэргүүний хэрэгцээ нь өөрийн үнэлэмжийг нэмэх, бие махбодоос зайлсхийх буюу бие махбодтой холбоотой сөрөг мэдрэмжүүдтэй ажиллах.
Гарсан ахиц өөрчлөлт: Сэтгэл зүйн хамгаалалт буурч, далд байсан гэмших мэдрэмж уур бухимдал руу шилжсэн, сэтгэл зүйн хувьд нээгдэх, өөрийгөө илэрхийлэх хүсэл нэмэгдэж, өөртэй холбоотой сөрөг мэдрэмж буурсан үр дүн ажиглагдлаа.
Цаашид авах арга хэмжээ: Тиймээс цаашид уур бухимдлыг гадагшлуулах, өөрийгөө хүлээн зөвшөөрөх, хувь хүний хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдэд хамруулж үргэлжлүүлэн ажиллах хэрэгтэй.

ДҮГНЭЛТ

Нийт 2 тестийн үнэлгээгээр судлуулагчийн сэтгэл зүйн хамгаалалт буурч, далд байсан гэмших мэдрэмж уур бухимдал руу шилжсэн, сэтгэл зүйн хувьд нээгдэх, өөрийгөө илэрхийлэх хүсэл нэмэгдэж, өөртэй холбоотой сөрөг мэдрэмж буурсан үр дүн ажиглагдлаа. Тиймээс цаашид уур бухимдлыг гадагшлуулах, өөрийгөө хүлээн зөвшөөрөх, хувь хүний хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдэд хамруулж үргэлжлүүлэн ажиллах хэрэгтэй.

НОМ ЗҮЙ

[1]. Б.Ганчимэг. Сэтгэл зүйн гарын авлага. Улаанбаатар, 2018

[2]. О.Мягмар. Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд Улаанбаатар, 1999

[3]. Роман Стриженец. Хямралын үед үзүүлэх үйлчилгээ, Улаанбаатар, 2013

[4]. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын хүүхдүүдийн гэр бүл, нийгмийн байдлын судалгаа